

5.3. Хэлэлцэж байгаа асуудлын сэдэв, танилцуулсан хүн, байлцсан хүмүүс, хэлэлцэж байгаа асуудал бүртэй холбогдон гарсан асуулт, хариулт, санал шүүмжлэл, гаргасан санал, дүгнэлтийг дэлгэрэнгүй бичнэ.

5.4. Тухайн асуудлаар хурлаас гарах шийдвэрийн төслийг олонхийн саналаар баталсан санал хураалтын дүн, татгалзсан тэргүүлэгчийн тоо, шаардлагатай бол татгалзсан тэргүүлэгчийн нэрийг түүний саналын дагуу тэмдэглэнэ.

5.5. Хурлын тэмдэглэлд хуралд анх оруулсан шийдвэрийн төсөл, танилцуулга, дүгнэлт, санал, тооцоо судалгааны хамт хэлэлцсэн дарааллаар нь дугаарлан хавсаргана.

5.6. Хурлын тэмдэглэлд хурлын нарийн бичгийн дарга болон тэмдэглэл хөтөлсөн тэргүүлэгч гарын үсэг зурах бөгөөд Хурлын дарга танилцан гарын үсэг зурж тамга дарсанаар хүчин төгөлдөр болно.

5.7. Шийдвэрийг нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, түүний билэлтэд хяналт тавих ажлыг тэргүүлэгчид, ажлын алба гүйцэтгэнэ.

5.8. Тэргүүлэгчдийн хурлаас гарсан тогтоол, тэмдэглэлийн эх хувийг сумын ИТХ-ын дэргэдэх архивт жил бүр хадгалж, аймгийн Төрийн архивт 8 жил тутам зохих журмын дагуу шилжүүлж байна.

Зургаа. ШИЙДВЭРИЙГ ЁСЧЛОХ

6.1. Хурлын шийдвэрийг хуралд оролцсон нийт тэргүүлэгчдийн олонхийн саналаар батална.

6.2. Хуралд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

6.3. Хурлаас гарсан шийдвэрийн эхийг уншиж сонсгох, хэвлэх, гарын үсэг зуруулах, тамга дарж баталгаажуулах, шийдвэрийг ёсчлох ажлыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга хариуцна.

Долоо. ТЭРГҮҮЛЭГЧИЙН ЁС ЗҮЙ.

7.1. Тэргүүлэгчдийн хуралд тэргүүлэгчид хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй бөгөөд хурлын тогтоол гарсанаар эцсийн хариуцлага хүлээнэ.

7.2. Тэргүүлэгчид өөр аймаг, нийслэл, гадаад улс оронд ажил, амралтаар явах нөхцөлд Хурлын даргад урьдчилан мэдэгдэнэ.

7.3. Тэргүүлэгчдийн өөртэй нь болон хамаарал бүхий этгээдтэй холбоотой асуудал хэлэлцэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхгүй, аливаа ашиг сонирхолын зөрчлөөс ангид байна.

Найм. ХУРЛЫГ ХААХ

Хурлаар хэлэлцэх асуудлаа дууссан гэж хуралд оролцсон тэргүүлэгчдийн олонх үзсэн тохиолдолд Хурлын дарга / хурал даргалагч/ албан ёсоор мэдэгдэж хаана.

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД